



Хувьцаа эзэмшигчдийн хурлын  
2024 оны 05 сарын 16 өдрийн  
02 дугаар тогтоолын хавсралт

**“ЭРДЭНЭС МЕТАН”  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

**1.1. Компанийн ерөнхий мэдээлэл**

1.1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Эрдэнэс метан” ХХК (цаашид “компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, тэдгээрийн эрх, үүрэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхойлох, “Эрдэнэс Монгол” нэгдлийн хэмжээнд хэрэгжүүлэх компанийн засаглалын бодлогыг баримтлах, үйл ажиллагааг уялдуулах, хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлж хувьцаа эзэмшигчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.1.2. Компанийн оноосон нэр “Эрдэнэс метан” ХХК, англи хэлээр “Erdenes methane” LLC, товчилсон нэр “ЭМет” ХХК байна.

1.1.3. Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний гүйцэтгэх удирдлага байршиж байгаа газраар тодорхойлно.

**1.2. Компанийн зорилго, үйл ажиллагааны чиглэл**

1.2.1. Компанийн үндсэн зорилт нь улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмрээ оруулан, хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино. Компани нь дор дурдсан үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:

1.2.1.1. Уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эрэл, судалгаа;

1.2.1.2. Газрын тостой холбоотой үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татах;

1.2.1.3. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт;

1.2.1.4. Энэ дүрмийн 1.2.1.1 - 1.2.1.3-т заасан чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

1.2.2. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

1.2.3. Компани нь хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах эрхтэй.

**Хоёрдугаар бүлэг. Компанийн хувьцаа, ногдол ашиг**

**2.1. Компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө**

2.1.1. Компани нь нэг бүр нь 1 (нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000 (нэг сая) ширхэг энгийн хувьцаатай байна.

2.1.2. Компани нийт зарласан энгийн хувьцааны тоонд багтаан хувьцаа шинээр гаргах, хувьцааг эргүүлэн худалдан авах асуудлыг Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

2.1.3. Компанийн төрийн өмчлөлийн хувьцаа эзэмшигч нь “Эрдэнэс Монгол” ХХК байна.

2.1.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь гаргасан нийт энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнтэй тэнцүү байна.

## Гуравдугаар бүлэг. Компанийн засаглалын тогтолцоо

### 3.1. Компанийн нэгдэл

3.1.1. Компани нь өөрөө болон түүний толгой, охин, зэргэлдээ компани, хуулийн этгээд, төслийн нэгжүүдээс бүрдсэн нэгдэл (цаашид “нэгдэл” гэх)-ийн зохион байгуулалтад орж үйл ажиллагаа явуулна.

3.1.2. Компани нь толгой компанитай үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор менежментийн гэрээ байгуулж, хэрэгжүүлж ажиллана.

3.1.3. Энэ дүрмийн 3.1.2-т заасан гэрээний дагуу компани нь толгой компанид менежментийн төлбөр төлнө. Менежментийн төлбөрийн хувь хэмжээг толгой компанийн дүрэмд заасан хязгаарт багтаан Менежментийн гэрээнд тусгана.

3.1.4. Компани нь нэгдлийн зохион байгуулалтыг уялдуулах зорилгоор компанийн зохион байгуулалтын бүтцэд нэгдсэн стратеги төлөвлөлт, санхүүгийн нэгдсэн удирдлага, үйлдвэрлэл технологийн асуудал хариуцсан нэгжтэй байх ба тухайн бүтцийн нэгжийн удирдлагыг толгой компанитай зөвшилцөж, түүний саналаар томилно.

3.1.5. Компани нь толгой компанийн дүрэм, толгой компаниас гаргасан бодлого, нэгдлийн хэмжээнд дагаж мөрдөх журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах бөгөөд дээд шатны байгууллага болон Засгийн газар, УИХ, ҮАБ-ын зөвлөлд танилцуулах шаардлагатай асуудлаа толгой компаниар дамжуулан танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.1.6. Компанийн Гүйцэтгэх удирдлага гадаадад албан томилолтоор ажиллах тохиолдолд толгой компанийн Гүйцэтгэх удирдлагаар томилолтын удирдамжийг батлуулж, батлагдсан удирдамжийн дагуу ажиллана.

### 3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал

3.2.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

3.2.2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг жилд 1 (нэг)-ээс доошгүй удаа хуульд заасны дагуу хуралдуулна.

3.2.3. Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хуралдуулна.

3.2.4. Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 60.3-т заасан хугацааг баримтлахгүйгээр шаардлагатай үед хуралдуулж болно.

- 3.2.5. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 3.2.5.1. Нэгдлийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах;
  - 3.2.5.2. Нэгдлийн хэмжээнд мөрдөх бодлого, журам батлах;
  - 3.2.5.3. Менежментийн төлбөрийн хувь хэмжээг тогтоох;
  - 3.2.5.4. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;
  - 3.2.5.5. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
  - 3.2.5.6. Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
  - 3.2.5.7. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
  - 3.2.5.8. Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
  - 3.2.5.9. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
  - 3.2.5.10. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
  - 3.2.5.11. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
  - 3.2.5.12. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
  - 3.2.5.13. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
  - 3.2.5.14. Компанийн засаглал, эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих;
  - 3.2.5.15. Компанийн зохион байгуулалтын бүтцийг батлах, орон тооны дээд хязгаарыг тогтоох;
  - 3.2.5.16. Компанийн Гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргах эрх хэмжээний хязгаарыг тогтоох;
  - 3.2.5.17. Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах;
  - 3.2.5.18. Ёс зүйн дүрэм батлах.

### **3.3. Гүйцэтгэх удирдлага**

3.3.1. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх захирал нь дараах бүрэн эрх хэмжээг хэрэгжүүлнэ:

3.3.1.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

3.3.1.2. Хувьцаа эзэмшигчийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

3.3.1.3. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

3.3.1.4. Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, хувьцаа эзэмшигчид танилцуулан батлуулах;

3.3.1.5. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн эрх

бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, стандарт, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, толгой компаниас ирүүлсэн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

3.3.1.6. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

3.3.1.7. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

3.3.1.8. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахгүй байх;

3.3.1.9. Баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас чөлөөлөх;

3.3.1.10. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг зохих хуульд заасны дагуу шийдвэрлүүлэх;

3.3.1.11. Компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

3.3.1.12. Компанийн үйл ажиллагааны дотоод журмыг баталж мөрдүүлэх;

3.3.1.13. Батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд худалдан авалтын төлөвлөгөө батлах.

3.3.2. Гүйцэтгэх захирал нь доорх шалгуурыг хангасан байх бөгөөд гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулж сонгоно.

3.3.2.1. 5-аас доошгүй жил Гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай, төрийн удирдлага, бизнесийн удирдлага, эрх зүй, санхүү эдийн засаг, эсвэл уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр дээд боловсролтой байх;

3.3.2.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

3.3.2.3. Ял шийтгэлгүй байх;

3.3.2.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

3.3.3. Гүйцэтгэх захиралд тавигдах мэргэжил, мэргэшил, ажлын туршлага, ур чадварын шалгуур болон бусад шалгуур, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг хууль, журамд нийцүүлэн толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталж мөрдүүлнэ.

3.3.4. Гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 3.3.3 дугаар зүйлд заасан журмаар тогтоосон шалгуурыг хангасан байх бөгөөд гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулж сонгоно.

3.3.5. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь холбогдох хууль тогтоомж, гэрээ болон энэхүү дүрмийн 3.3.3-т тусгагдсан журамд заасан үндэслэлээр дуусгавар болно.

#### **3.4. Эрх бүхий албан тушаалтан**

3.4.1. Компанийн тухай хуулийн 84.1-д заасны дагуу Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, бүтцийн нэгжийн удирдлагыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

## **Дөрөвдүгээр бүлэг. Компани болон түүний удирдлагын хариуцлага**

### **4.1. Компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага**

4.1.1. Компанийн энгийн хувьцааг эзэмшигчийн хариуцлага нь компанид оруулсан хөрөнгийн хэмжээгээр хязгаарлагдана;

4.1.2. Компани нь хувьцаа эзэмшигчийн хүлээсэн санхүүгийн болон бусад үүргийг хариуцахгүй.

### **4.2.2. Компанийн удирдлагын хариуцлага**

4.2.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, компаниас хувьцаа эзэмшигчид өгөх өгөөжийг байнга нэмэгдүүлэх үүрэг хүлээж ажиллана. Үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ;

4.2.2. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд тухайн албан тушаалд томилогдсон байх хугацаандаа Монгол Улсын Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээнэ.

## **Тавдугаар бүлэг. Компанийн санхүүгийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хяналт**

### **5.1. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал**

5.1.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (англи хэлээр "International Accounting Standards", товчилсноор "IAS"), санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (англи хэлээр "International Financial Reporting Standards", товчилсноор "IFRS")-ын дагуу хөтөлж, тайлагнана.

5.1.2. Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

### **5.2. Компанийн санхүүгийн хяналт**

5.2.1. Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт тавих зорилгоор жил бүр хөндлөнгийн аудит хийлгэнэ.

5.2.2. Компани нь өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд дотоод хяналт тавих зорилгоор дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэгч нэгж /мэргэжилтэн/-тэй байх ба энэхүү нэгж /мэргэжилтэн/ нь хувьцаа эзэмшигчид ажлаа тайлагнана.

5.2.3. Энэхүү дүрмийн 5.2.2-д заасан нэгжийг байгуулаагүй тохиолдолд толгой компанийн холбогдох нэгж ажилтан дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлж болно.

5.2.4. Компанийн дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоог Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар бүрдүүлнэ.

## Зургаадугаар бүлэг. Бусад асуудал

### 6.1. Компанийн нээлттэй, ил тод байдал

6.1.1. Компани нь ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор компани, нэгдлийн үйл ажиллагааны зорилго, чиглэл, дүрэм, бүтэц, зохион байгуулалт, хувь оролцоо, санхүүгийн тайлан, гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, товч танилцуулга, ажлын туршлага, томилсон шийдвэрийн талаар болон хууль тогтоомжид заасан шаардлагатай мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.

### 6.2. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

6.2.1. Компанийн их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

### 6.3. Компанийн хэлбэр өөрчлөх, нэгтгэх, татан буулгах

6.3.1. Компанийн хэлбэрийг өөрчлөх, татан буулгах үйл ажиллагааг Компанийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна.

-----ooOoo-----